



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт



**Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих
чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар олгогдсон
үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

2016 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймгийн аудитын газар Аймгийн Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Аудитор Г.Наранбаяр 2016 оны 11, 12 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т заасан байгууллагуудаас нийт 15 байгууллага, сан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна. 1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагуудаас 2 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. 1.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т хамаарах байгууллага байхгүй бөгөөд дээрх хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан сангуудаас нийт 8 сан бие даасан цэс нээлгээгүй байна. 1.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарагдаж буй Төрийн өмчит 5 хувьцаат компанийн орон нутаг дахь салбар байгууллагууд бие даасан цэс нээлгээгүй байна. Бүлэг 2. Аудитад хамрагдсан байгууллагын 51.0 хувь нь хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. 2. 2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан зарим байгууллага болон аймгийн төрийн болон орон нутгийн өмчит нийт 21 байгууллага мэдээллээ дутуу оруулсан, 2 байгууллага мэдээллээ оруулаагүй, 5 байгууллага мэдээллээ маягтын дагуу мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ. 2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.2-т хамаарал бүхий этгээдийн 49.0 хувь нь 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг бүрэн оруулж, 47.0 хувь нь алдаатай буюу дутуу оруулсан бол 4.0 хувь нь цэс нээлгэсэн боловч огт мэдээлэл байршуулаагүй байна.
---	--

	2.3. Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан мэдээллийг байршуулаагүй байна. 2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Шивээ овоо” ХК нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг байршуулаагүй байна. Бүлэг 3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. 3.1. Аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байгууллагын 51.0 хувийнх нь байршуулсан мэдээлэл зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна Бүлэг 4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. 4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт 63.0 хувь, зөвлөмжийн биелэлт 50.0 хувьтай байна. Дүгнэлт..... Зөвлөмж.....
--	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НАГ	Нийцлийн аудитын газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УБСГ	Улсын бүртгэл, статистикийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨҮААГ	Орон нутгийн өмчит үйлдвэр, аж ахуйн газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДС	Нийгмийн даатгалын сан
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

Аймгийн төрийн болон улс, орон нутгийн өмчит байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, аудитаар илэрсэн эрсдэлийг үнэлэн холбогдох дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын НАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, мөн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байхад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнуудыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэл, Нийцлийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа, ил тод, нээлттэй ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий Шилэн дансны тухай хууль 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 93 хуулийн этгээд, байгууллага шилэн дансны цахим хуудсанд бие даасан цэс нээлгэж, мэдээллээ байршуулахаас 78 хуулийн этгээд, байгууллага мэдээллээ бүрэн байршуулж, 15 хуулийн этгээд мэдээллээ байршуулаагүй байна. Тухайлбал: Өмнөх шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар Шилэн дансны цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байсан дор дурдсан байгууллагууд бие даасан цэсээ нээлгэсэн ба зарим сумдын сум хөгжүүлэх сангууд бие даасан цэсээ нээлгээгүй байна. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2016 оны 1 дүгээр улиралд “Хонгорхон”, “Буян”, “Олуулаа”, “Бүжинхэн” гэсэн хувийн цэцэрлэгүүд мөн аймгийн Нийгмийн даатгалын сан, Сүмбэр сумын Сум хөгжүүлэх санд бие даасан цэс нээлгэж, Шивээговь, Баянтал сумдын Сум хөгжүүлэх, Байгаль хамгаалах, Мал хамгаалах сангууд төсвийн тодотгол хийгдээгүйтэй холбоотойгоор цэс нээлгээгүй байна.

Аймгийн болон сумдын ИТХ, иргэдийн нийтийн хурлаас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх

Бүлэг 1

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т заасан байгууллагуудаас нийт 15 байгууллага, сан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

1.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллагуудаас 2 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийж буй Нийцлийн аудитаар аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн өмчит нийт 93 байгууллага, сан, төсөл хөтөлбөрүүдийг хамруулан шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 79 цэс нээгдсэн байна. Үүнд: улсын төсвийн 19, орон нутгийн төсвийн болон тусгай шилжүүлгийн 35, төрийн өмчит 3, орон нутгийн өмчит 6, орон нутгийн болон Засгийн газрын тусгай сан 12, хувийн 4 цэцэрлэг байна.

Аймгийн хэмжээнд шилэн дансны цэс нээлгээгүй нийт 15 байгууллага сан байгаагаас Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т хамаарч байгаа дараах 2 байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. Үүнд: аймгийн Тагнуулын тасаг, аймгийн Чөлөөт ахмадын холбоо гэсэн байгууллагууд цэс нээлгээгүй байна.

Аймгийн Чөлөөт ахмадын холбоо нь 2015 оноос Ахмадын хорооны санхүүжилтийг шилжүүлэн авч үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд 2016 оны 08 сар хүртэл 11,034.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгэж, мэдээлэл байршуулаагүй байна.

Харин Ахмадын холбоо нэртэй цэс нээгдсэн бөгөөд аймгийн Ахмадын хороо 2016 оны 10 дугаар сараас 2,758.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан боловч мэдээлэл оруулаагүй байна.

Говьсүмбэр аймаг дахь Тагнуулын тасаг нь нууцын зэрэглэлтэй гэсэн шалтгаанаар цэс нээлгээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-т “Төрийн нууцад хамаарахаас бусад төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналыг байгууллагын нууцад хамааруулан нийтэд мэдээлэхээс зайлсхийхийг хориглоно” гэснийг зөрчсөн байна. Үүнийг аудитын явцад тодруулахад 2016 оноос ТЕГ-т нэгтгэн мэдээлж байгаа гэсэн тайлбар өгсөн.

Сүмбэр сумын “Энхтусдэм” өрхийн эмнэлэг 2015 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэстэй байсан боловч 2016 оны шинэчлэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байсан бөгөөд аудитын явцад цэс нээлгэн холбогдох мэдээллийг байршуулсан байна.

Төсвийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт шинэчлэн өөрчлөгдөж, зарим байгууллагуудын нэршил солигдсоноос шалтгаалан шинээр цэс нээлгэсэн, мөн зарим байгууллагын нэрийг устгуулснаас өмнөх мэдээллүүдийг харах боломжгүй болсон байна. Тухайлбал,

1. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтсийг нэгтгэж Улсын бүртгэл, статистикийн хэлтэс болгон өөрчилсөнтэй холбоотойгоор 2016 оны 1 дүгээр сараас шилэн дансны мэдээллийг Улсын бүртгэлийн хэлтсийн цэсэнд мэдээлж ирсэн бөгөөд аудитын явцад чиглэл өгсний дагуу байгууллагын нэрийг Улсын бүртгэл, статистикийн газар болгон өөрчилж, Статистикийн хэлтсийн цэсийг устгуулсан болно.

Гэтэл 2016 оны 08 дугаар сараас Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтсүүд салж, тусдаа статустай байгууллага болон ажиллаж байгаа бөгөөд өмнөх нэрээр оруулж байсан бүх мэдээллүүд устгагдсан байна. Иймд Улсын бүртгэлийн хэлтэс цэсэнд өмнөх саруудын мэдээллийг нөхөн оруулсан бөгөөд Статистикийн хэлтэс нэрээр шинээр цэс нээлгэн 08 дугаар сараас холбогдох мэдээлүүдийг байршуулсан байна.

2. 2016 оны 08 дугаар сараас Аймгийн Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс, Хөдөлмөрийн хэлтсийг нэгтгэн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болгон өөрчилсөнтэй холбоотойгоор Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар шинээр цэс нээлгэн 08 дугаар сараас мэдээллийг байршуулсан байна. Харин Хөдөлмөрийн хэлтсийн цэсийг устгаснаас 2016 оны 01-08 саруудын мэдээллийг харах боломжгүй болсон байна. Нийгмийн халамжийн үйлчилгээний хэлтэс цэсэнд 2016 оны 08 дугаар сар хүртэлх холбогдох мэдээлэл харагдаж байна.

Орон нутгийн байгууллагуудыг бүтцийн өөрчлөлтөөр нэгтгэсэн болон нэр хаягыг нь өөрчилснөөс шалтгаалан байгууллагуудын мэдээлэл устгагдаж өмнөх мэдээллүүдийг харах боломжгүй болгож байгаа нь уг хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд холбогдох байгууллагуудын мэдээллийг аль нэг байгууллагын өмнөх цэсэнд хадгалагдаж байхаар зохицуулалт хийх нь зүйтэй юм.

1.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т хамаарах байгууллага байхгүй бөгөөд дээрх хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасан сангуудаас нийт 8 сан бие даасан цэс нээлгээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т хамаарах нийт 8 сан Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. Үүнд: аймгийн Засаг даргын нөөц сан нь батлагдсан төсөвтэй боловч бие даасан цэс нээлгээгүй бөгөөд харин дараах 7 сан төсөв батлагдаагүй гэсэн шалтгаанаар нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байна. Үүнд:

1. Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл,
2. Баянтал сумын Сум хөгжүүлэх сан,
3. Шивээговь сумын Сум хөгжүүлэх сан,
4. Баянтал сумын Байгаль хамгаалах сан,
5. Шивээговь сумын Байгаль хамгаалах сан,
6. Баянтал сумын Мал хамгаалах сан,
7. Шивээговь сумын Мал хамгаалах сан бие даасан цэсгүй байна.

Авто замын санд 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байсан бөгөөд 2016 оны 05 дугаар сард нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэн холбогдох мэдээллийг нөхөн оруулсан байна.

Үйл ажиллагаа явуулж буй дээрх сангуудын төсвийг өмнөх онд нь батлуулаагүйгээс цэс нээх боломжгүй болсон байна. Иймд холбогдох эрх бүхий байгууллагаар жил бүрийн төсвийг батлуулж, төсөв батлагдаагүй ч уг сангуудын дансдад төвлөрсөн хөрөнгө, түүний зарцуулалтыг Шилэн дансны тухай хуулийн дагуу бүрэн мэдээлж байх нь зүйтэй.

Аймгийн Засаг даргын нөөц сангийн төсөв нь аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн ЗДТГ-ын төсөвт зардлын нэг зүйл ангиар батлагдан зарцуулагдаж байгаагаас шалтгаалан бие даасан цэс нээлгээгүй байна.

1.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарагдаж буй Төрийн өмчит 5 хувьцаат компанийн орон нутаг дахь салбар байгууллагууд бие даасан цэс нээлгээгүй байна.

Төрийн өмчит 5 хувьцаат компанийн орон нутаг дахь салбаруудын мэдээллийг төв компанийн цэсэнд мэдээлж байгаа учраас орон нутагт бие даасан цэс нээлгээгүй байна. Үүнд:

1. Цахилгаан дамжуулах сүлжээ,
2. Цахилгаан түгээх сүлжээ,
3. Монголын цахилгаан холбоо,
4. Мэдээлэл харилцаа холбоо,
5. Шуудан үйлчилгээний газар

Дээрх байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “Шилэн дансны бие даасан цэстэй байх” гэснийг тус тус зөрчиж байгаа боловч уг хуулинд салбар байгууллага тус бүрээр шилэн дансны цахим хуудсанд цэс нээх эсвэл, нэгтгэж мэдээлэх талаар тодорхойгүй байна.

Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх

Бүлэг 2

Аудитад хамрагдсан байгууллагын 51.0 хувь нь хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

2.1. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан зарим байгууллага болон аймгийн төрийн болон орон нутгийн өмчит нийт 21 байгууллага мэдээллээ дутуу оруулсан, 2 байгууллага мэдээллээ оруулаагүй, 5 байгууллага мэдээллээ маягтын дагуу мэдээлээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд тухайн жилийн төсвийг бүрэн байршуулсан байна. Харин аймгийн Боловсрол соёл, урлагийн газар төсвийн дүнг мянгачилж оруулсан боловч гүйцэтгэлийн дүнг төгрөгөөр оруулсан нь Шилэн дансанд дахь мэдээллийг зөрүүтэй харагдуулах нөхцлийг бий болгосон байна.

2016 оны 10 сарын байдлаар дор дурдсан 21 байгууллагууд шилэн дансанд мэдээлэл байршуулах зааврын дагуу төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг оруулаагүй, төсвийн гүйцэтгэлийг системээс татаагүй байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ
2. Аймгийн ЗДТГ
3. Байгаль орчин, аялал жуулчлалын газар
4. Санхүүгийн хяналт аудитын алба
5. Боржигин чуулга
6. Сум дундын ойн анги
7. Сүмбэр сумын ЗДТГ
8. Сүмбэр сумын 1 дүгээр цэцэрлэг
9. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг
10. Баянтал сумын ИТХ
11. Баянтал сумын ЗДТГ
12. Баянтал сумын 3 дугаар сургууль
13. Баянтал сумын Эрүүл мэндийн төв
14. Шивээговь сумын ИТХ
15. Шивээговь сумын ЗДТГ
16. Шивээговь сумын 3 дугаар сургууль
17. Шивээговь сумын Эрүүл мэндийн төв
18. Цөм сүрэг үржлийн төв

- 19.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- 20.Авто замын сан
- 21.Насан туршийн боловсролын төв

Ахмадын сангийн цэсийг Ахмадын холбоо болгон өөрчилсөн боловч ямар ч мэдээлэл оруулаагүй байна.

Аймгийн Нийгмийн даатгалын санд бие даасан цэс нээлгэсэн бөгөөд 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар хуучин цахим хуудсанд нийгмийн даатгалын сангаас авсан болон олгосон мэдээлэл оруулж байсан хэсэг байхгүй болж, тус сангийн мэдээлэл оруулахад утга тохироогүйгээс холбогдох мэдээллийг зөвхөн PDF форматаар файл болгон хавсаргаж байсан бөгөөд 2016 оны 10 дугаар сараас өмнөх мэдээлэл оруулах хэсэг нэмэгдсэний дагуу 01 дүгээр сараас эхлэн холбогдох мэдээллийг нөхөж оруулсан байна.

“Шивээ-Овоо” ХК худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Худалдан авах ажиллагааны тайлан, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийн мэдээллүүдийг оруулаагүй байна.

“Говьсүмбэр аймаг” цэсэнд аймгийн төсөв, гүйцэтгэлийн нэгтгэсэн ерөнхий мэдээллийг оруулж байгаагаас гадна аймгийн ОНХС-гийн төлөвлөгөө гүйцэтгэл, улсын төсөв болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, ТЕЗ-ийн хөтөлбөрийн үр дүн, худалдан авах ажиллагаа, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг файлаар хавсаргаж оруулсан байна. Үүнээс: Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт хэсэгт мэдээллийг зөвхөн файлаар оруулсан байгаа нь уг мэдээллийг үзэхийн тулд заавал татаж авч үзэх зэрэг дутагдалтай талууд байна.

“Сүмбэр сум” цэсэнд Сүмбэр сумын ОНХС-гийн төлөвлөгөөний мэдээллийг маягтын дагуу оруулалгүй файлаар хавсаргасан байна.

“Баянтал сум” цэсэнд тус сумын ОНХС-гийн болон орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн мэдээлэл оруулж байгаа боловч уг сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг оруулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.6-д “төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтнааны тайлбарыг улирал бүр” гэснийг тус зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь байгууллагуудын шилэн данс хариуцсан ажилтнууд шилэн дансанд холбогдох мэдээллийг оруулахдаа файлаар оруулахаас гадна нэгдсэн цахим хуудас дахь маягтыг бүрэн бөглөх, холбогдох мэдээллийг системээс татаж байхаар тохируулга хийх талаар нэгдсэн ойлголтгүй байгаагаас шалтгаалсан байна.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1, 3.2.2-т хамаарал бүхий этгээдийн 49.0 хувь нь 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг бүрэн оруулж, 47.0 хувь нь алдаатай буюу дутуу оруулсан бол 4.0 хувь нь цэс нээлгэсэн боловч огт мэдээлэл байршуулаагүй байна.

Шилэн дансны дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллүүдийг маягт бөглөх зааварчилгааны дагуу бөглөөгүй, мөн таван сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгнөөс дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт зарим байгууллага санхүүжилтийн орлогыг зарим саруудад дутуу мэдээлсэн бол зарим нь огт мэдээлээгүй байна.

Дор дурдсан байгууллагууд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ буюу санхүүжилтийн нийт 2,493,123.5 мянга, зарлагын гүйлгээг 109,734.7 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Мэдээллээ дутуу байршуулсан байгууллагуудын судалгааг хүснэгтээр харуулбал:


/мянган төгрөгөөр/			
Д/д	Байгууллагын нэр	Орлого	Зарлага
1	Шүүхийн тамгын газар	654 133,5	51 411,9
2	Прокурорын газар	108 189,9	
3	Татварын хэлтэс	59 696,9	
4	Боловсрол, соёлын газар	73 265,2	
5	Онцгой байдлын газар	492 719,8	28 849,9
6	Мэргэжлийн хяналтын газар	200 458,4	-
7	ГХБХБГ	99 834,4	6 041,7
8	Улсын нөөцийн салбар	66 570,4	
9	Баянтал сумын ИТХ	20 268,6	
10	Баянтал сумын ЗДТГ	150 185,4	
11	Баянтал сумын Эрүүл мэндийн төв	132 843,2	
12	Шивээговь сумын ИТХ	35 645,2	
13	Шивээговь сумын Эрүүл мэндийн төв	228 432,7	
14	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс	170 879,9	23 431,1
Нийт дүн		2 493 123,5	109 734,7
		2 602 858,2	

Дээрх хүснэгтээс харахад Шилэн дансны тухай хуулийн зөвхөн 1 заалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зарим байгууллага санхүүжилтийн орлогоо дутуу, зарим нь огт байршуулаагүй байгаа нь Шилэн дансны

нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах талаар нэгдсэн ойлголтгүй байгаатай холбоотой байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээсэн байгууллагын мэдээлэл оруулсан байдлыг диаграммаар харуулбал:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байгууллагуудын мэдээлэл оруулсан байдал /тоо, хувиар/



Диаграммаас харахад нийт 79 цэс нээлгэснээс 49.0 хувь буюу 36 байгууллага мэдээлэл бүрэн оруулж, 47.0 хувь буюу 35 байгууллага мэдээллийг алдаатай буюу дутуу оруулсан бол 4.0 хувь буюу 3 байгууллага огт мэдээлэл байршуулаагүй байна.

Байгууллагууд Шилэн дансны хуулийн дагуу Шилэнд дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулахдаа дараах алдаа, зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Хөрөнгө зарцуулах болон тэтгэмж олгосон тушаал, шийдвэрийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй, зарим байгууллага эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн мэдээлэл оруулсан боловч уг шийдвэрийг файлаар байршуулаагүй,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний хэсэгт ихэнх байгууллагууд холбогдох мэдээллийг дутуу оруулсан бөгөөд өссөн дүнгээр оруулах байтал тухайн сард гарсан 5,000.0 мянган төгрөгнөөс дээш үнийн дүнтэй гүйлгээний мэдээлэл оруулсан,
- Ажил гүйлгээ гараагүй гэж мэдээлсэн зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал: Сүмбэр сумын ОНХС-гийн мэдээллийг 2016 оны 03 дугаар сард 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлаас 3,182.9 мянган төгрөгийн зарцуулалтын мэдээллийг оруулалгүй, худалдан авалтын хэсэгт ажил гүйлгээ гараагүйгээр мэдээлсэн,
- Мөн таван сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй худалдан авалтыг мэдээлэх хэсэгт зардлыг өссөн дүнгээр мэдээлээгүй,
- Шивээговь сумын ИТХ, 3 дугаар сургууль, 3 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан

авалтын мэдээг өссөн дүнгээр оруулаагүй, тэтгэмж олгосон болон хөрөнгө зарцуулах тухай тушаал, шийдвэрүүдийн мэдээллийг байршуулсан боловч хавсралт файлаар оруулаагүй, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбарыг дутуу, орон тоо нэмэгдэж, хасагдсан өөрчлөлтөд тайлбар бичээгүй,

- Аймгийн болон Сүмбэр, Баянтал сумдын ОНХС-гийн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг шивж оруулсан боловч файлаар оруулаагүй,
- “Шивээ-Овоо” ХК нь ТУЗ-ийн тогтоолуудыг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлээгүй, тендерийн урилганаас бусад нээлттэй тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой баримт материал, мөн тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн товч мэдээлэл, тендерийн үнэлгээний хорооны дүгнэлт зэргийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулаагүй байна.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь “Шивээ-Овоо” ХК-ийн цэсэнд төсөв, гүйцэтгэл хэсгийн цалингаас бусад орлого, зарлагын мэдээллүүдийг оруулсан боловч Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төрийн өмчит хувьцаат компаниудын зөвхөн тендер болон худалдан авах ажиллагааны талаарх мэдээллүүдийг оруулахаар шинэ журмын дагуу тохиргоо хийгдсэнээр өмнөх мэдээлэл оруулсан хэсэг харагдахгүй болсон байна.


Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.2-т “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын товч мэдээлэл, шалгарсан болон шалгаруулаагүй хуулийн үндэслэл, шалтгаан”-ыг 7 хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Зарим ажилтнуудын хайхрамжгүй үйл ажиллагаанаас тоон мэдээллийг алдаатай оруулах, зарим мэдээллийг буруу хэсэгт андуурч оруулсан, мөн тухайн ажилтан мэдээлэл оруулах талаар бүрэн ойлголтгүй байгаа зэрэг нь тухайн байгууллагын хувьд мэдээлэл хэрэглэгчдэд буруу мэдээлэл өгөх эрсдэлтэй байна. Тухайлбал, аймгийн ШШГА-ны шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтан нүүрсний зардлын 4,000.0 мянган төгрөгийг 40,000.0 мянга гэж оруулснаас 36,000.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн, Шивээговь сумын ИТХ-д таван сая төгрөгнөөс дээш мэдээлэх зардал байхгүй байхад тус сумын ЗДТГ-ын 14,421.8 мянган төгрөгийн зардлыг андуурч мэдээлсэн байна.

Орон нутгийн зарим байгууллага, хуулийн этгээдүүд Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд нь мэдээллээ байршуулаагүй байна.

Холбогдох мэдээллийг байршуулсан хугацааг графикаар харуулбал:

Холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулсан байдал



Графикаас харахад нийт байршуулсан мэдээллийг 23 хувь нь хугацаа хоцорсон байна.

Иймд зөрчил гаргасан дээрх байгууллагуудын зөрчил арилгуулахаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3. Шилэн дансны тухай хуулийн 3.1-д хамаарах байгууллагууд хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан мэдээллийг байршуулаагүй байна.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй этгээдийн мэдээллийг 2016 оны 01 дүгээр улирлын байдлаар хуучин цахим хуудсанд оруулж байсан боловч шинэчлэгдсэн цахим хуудсанд уг мэдээллийг оруулахад утга тохирохгүй болсноос аймгийн Нийгмийн даатгалын сангийн цэсэнд холбогдох мэдээллийг зөвхөн PDF форматаар файл болгон хавсаргаж ирсэн байна. Харин 2016 оны 10 дугаар сараас уг мэдээллийг оруулах хэсэг нэмэгдсэнээр өмнөх саруудын үйлчилгээ үзүүлсэн хүний тоо, олгосон санхүүжилтийн дүнг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн мэдээллийг төрөл бүрээр нь нөхөн байршуулсан байна.

Мөн аймгийн төсвийн байгууллагууд аймгийн Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрхтэй этгээдийн мэдээллийг оруулахад шинэчлэгдсэн Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тохирох утга байхгүйгээс уг мэдээллийг байршуулаагүй бөгөөд Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллийн маягт бөглөх зааварчилгаанд дээрх мэдээллийг зөвхөн Нийгмийн даатгалын ерөнхий газар бөглөхөөр заасан байна.

Иймд дээрх маягт бөглөх зааварчилгааны дагуу шилэн дансны мэдээлэл оруулдаг ажилтнуудад нэгдсэн журмаар мэдээлэл өгөх шаардлагатай байна.

2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д хамаарах “Шивээ овоо” ХК нь хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг байршуулаагүй байна.

“Шивээ-Овоо” ХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Худалдан авах ажиллагааны тайлан, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллүүдийг оруулаагүй байна.

Эдгээр зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1-д “тухайн байгууллагад холбогдох энэ хуулийн 3.2.5, 3.2.7, 3.2.8-д заасан шийдвэр”, 6.8.2-т “худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.8.3-т “төр болон орон нутаг тавь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компанийн гаргасан их хэмжээний хэлцэлд тооцогдохуйц баталгаа, батлан даалт” гэснийг тус тус заалтыг зөрчсөн байна.

“Шивээ-овоо” ХК-д дээрх мэдээллүүдийг бүрэн байршуулах талаар арга хэмжээ авч ажиллах, холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх

Бүлэг 3

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

3.1. Аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байгууллагын 51.0 хувийнх нь байршуулсан мэдээлэл зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1, 6.4, 6.8 заалтуудад зааснаар байгууллагуудын шилэн дансны нэгдсэн санд оруулсан мэдээллийг нэгтгэн Сангийн яаманд улирал бүр хүргүүлж ажилласан байна. Гэвч тус албан нь мэдээлэл дутуу оруулсан болон цалингаас бусад таван сая төгрөгнөөс дээш орлого, зарлагын гүйлгээний хэсэгт мэдээллийг ихэнх байгууллагууд өссөн дүнгээр 5,000.0 мянган төгрөг хүртлэх гүйлгээг мэдээлээгүй, зөвхөн тухайн сарын гүйлгээний 5,000.0 мянган төгрөгнөөс давсан гүйлгээний болон санхүүжилт, цалингийн мэдээллийг оруулсан алдаа зөрчил гаргасан байтал уг

зөрчлүүдийг арилгуулах, залруулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Мөн ихэнх байгууллага таван сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын хэсэгт өссөн дүнгээр мэдээлэлгүй, тухайн сарын гүйлгээг мэдээлсэн байна.

Аймгийн ТЕЗ болон Санхүүгийн хяналт, аудитын албанаас хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ хангалттай хэрэгжүүлж ажиллаагүйгээс аймгийн хэмжээнд нилээд зөрчил гарч байгаагаас гадна зарим байгууллага, сангууд цахим хуудсанд өөрийн бие даасан цэсээ нээлгээгүй, цэстэй боловч мэдээлэл байршуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь аймаг, сумдын ИТХ, багийн Иргэдийн нийтийн хурал, Төрийн сан болон ХАААлба зэрэг хуулийн хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллах байгууллагууд нь хуулиар хүлээсэн чиг үүргийн дагуу “Шилэн дансны тухай хууль”-ийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа болон бие даасан цэс нээлгээгүй байгууллагуудын холбогдох ажилтнуудад заавар зөвлөгөө өгөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, хуулийн дагуу цэс нээлгэх шаардлагатай байгууллага, сангуудын цэсийг бүрэн нээлгэж, мэдээллийг нь байршуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйтэй холбоотой байна.

Уг зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ”, 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэснийг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий байгууллагууд хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлж, гарсан алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх аймгийн хэмжээнд “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээлэл хариуцсан албан хаагчдад нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах, маягт бөглөх талаар зааварчилгаа өгөх, нэгдсэн нэг ойлголттой болгох арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Бүлэг 4

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт 63.0 хувь, зөвлөмжийн биелэлт 50.0 хувьтай байна.

4.1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага 63.0 хувийн хэрэгжилттэй байна.

Аймгийн ТЕЗ болон Санхүүгийн хяналт, аудитын албанд өмнөх аудитаар 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Харин албан шаардлагын биелэлт 63.0 хувьтай байгаа нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь зөвхөн орон нутгийн төсвийн байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болсноос шалтгаалсан бөгөөд Сангийн яамнаас уг чиглэлийг ирүүлсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй зарим байгууллагуудад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж цэс нээлгэсэн байна.

Мөн мэдээллээ дутуу буюу буруу байршуулсан, давхардуулсан, алдаатай оруулсан зарим байгууллагуудын зөрчлийг арилгуулсан боловч дээрх алдаа дахин давтагдсан байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 15 байгууллага, сан бие даасан цэс нээлгээгүй,
2. Аудитад хамрагдсан байгууллагын 62.5 хувь нь хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулаагүй,
3. Аймгийн хэмжээнд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгэсэн байгууллагын 51.0 хувь нь нэгдсэн цахим хуудсанд байршуулвал зохих мэдээллүүдээ дутуу, буруу байршуулсан, зарим нь байгууллага нь холбогдох мэдээллээ байршуулаагүй зэрэг зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байгаа,

4. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг 63.0 хувь, зөвлөмжийн биелэлтийг 50.0 хувиар тус тус биелүүлсэн байна.

5. Аудитад 79 байгууллага хамрагдсанаас нийт 41 байгууллагаас 2,653,279.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга Н.Алтанцэцэг нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-д төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ” гэсний дагуу аймгийн төсөвт байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллах,

2. Мэдээллээ дутуу буюу буруу байршуулсан, алдаатай оруулсан байгууллагуудын алдаа зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, аймгийн хэмжээнд “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээлэл хариуцсан албан хаагчдыг нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах, маягт бөглөх талаарх зааварчилгаа өгөх, нэгдсэн нэг ойлголттой болгох арга хэмжээг зохион байгуулах,

3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бие даасан цэс нээлгээгүй байгууллагуудад цэс нээлгэж, мэдээллийг нь бүрэн байршуулах,

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллах.

ҮАГ-ЫН НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн заалт бүрээр цэсийг ойлгомжтой болгох, холбогдох мэдээллүүдийн оруулсан огноо харагддаг байх нөхцлийг бүрдүүлэх зэргээр нэгдсэн цахим хуудсыг илүү боловсронгуй болгох

2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах эсэх нь тодорхойгүй зарим сан, байгууллага, мөн толгой компани, байгууллагууд дээрээ мэдээлэл нь нэгдсэн журмаар байрших салбар байгууллагуудын жагсаалтыг орон нутагт ирүүлэх, тодорхой болгох